



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА

2021 оны 06 дугаар
сарын 16-ны өдөр

№ 48

Улаанбаатар хот

ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ


Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг 11.1-11.7 дугаар зүйл “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн 2015-2020 оны нөхцөл байдалд хэсэгчилсэн дүн шинжилгээ, судалгаа хийсэн дүнг танилцуулж байна.

Нэг. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг сүүлийн 6 жилд 50775 бүртгэгдсэний 61.6 хувь нь нийслэлд, 19180 буюу 38.4 хувь нь орон нутагт бүртгэгджээ.


Жилийн дунджаар авч үзвэл жилд 8321, сард 693, өдөрт 23, цагт 1 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Зураг 1. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг бүртгэгдсэн нутаг дэвсгэрийг нийслэл, орон нутгаар нь харьцуулан харуулбал, /2015-2020 он/





Энэ төрлийн гэмт хэрэг 2020 онд 7405 бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад 860 буюу 10.4 хувиар буурсан бөгөөд нийслэлд 4564 буюу 61.1 хувь, 2841 буюу 38.9 хувь нь орон нутагт бүртгэгджээ. Гэмт хэргийн илрүүлэлт 74.1 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.9 хувиар өссөн. Эдгээр хэргийн 90.3 хувь нь хөнгөн, 5.7 хувь нь хүндэвтэр, 4 хувь нь хүнд ангиллын хэрэг байна.

Зураг 2. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн илрүүлэлт /2015-2020 он/



Энэ төрлийн гэмт хэрэг нь бусад төрлийн гэмт хэргийн илрүүлэлтээс харьцангуй өндөр байна.

Зураг 3. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэрээр нь харуулбал, 2020 он



Нийслэл хот болон хүн ам ихээр төвлөрсөн суурин газруудад энэ төрлийн гэмт хэрэг илүү олон бүртгэгдсэн байна. Орон нутагт 2020 онд үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн дундаж 135, дунджаас дээгүүр үзүүлэлттэй 10 аймаг, дунджаас доогуур үзүүлэлттэй 11 аймаг байгаагаас Төв аймагт 273, Орхон аймагт 214 буюу хамгийн их, Говь-Алтай аймагт 44, Говьсүмбэр аймагт 64 буюу хамгийн бага гэмт хэрэг бүртгэгджээ.

Нийслэлийн хэмжээнд энэ төрлийн гэмт хэргийн дундаж үзүүлэлт 253 байгаа ба Баянзүрх дүүргийн цагдаагийн газар хамгийн олон гэмт хэрэг бүртгэгдсэн бол Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Багануур, Багахангай дүүргүүдийн цагдаагийн хэлтэст хамгийн цөөн гэмт хэрэг бүртгэгджээ. Дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдэд бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад Чингэлтэй дүүрэгт 4.2 хувь, Налайх дүүрэгт 27.8 хувиар өсч, бусад дүүргүүдэд буурсан байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлгийн 11.2 дугаар зүйл “Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах”, мөн хуулийн 11.5 дугаар зүйл “Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүй учруулах” гэмт хэргүүд сүүлийн 6 жилийн хугацаанд бүртгэгдээгүй байна.

Зураг 4. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүний эрүүл мэнд хохирсон гомдол, мэдээлэл /2015-2020 онд/



Хүний эрүүл мэнд хохирсон гомдол, мэдээлэл
96592




Үүнээс гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол, мэдээлэл
115845



Сүүлийн 6 жилийн хугацаанд цагдаагийн байгууллагад хүний эрүүл мэндийн хохирсон талаарх гомдол, мэдээлэл 96592 ирснээс 50775 эрүүгийн хэрэг үүсгэж, 45817 эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан, зөрчлийн хэрэг нээж шалгасан, торгуулийн арга хэмжээ авсан, хуурамч дуудлага, мэдээлэл байсан, хохирогч гомдлоо буцаасан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол, мэдээлэл нь хүний эрүүл мэнд хохирсон гомдол, мэдээллээс 19253-аар илүү байна. Тодруулбал, 2015-2017 онд 26358 гомдол, мэдээлэл байсан бол 2018-2020 онд 89487 болж 29 хувиар өссөн.

Зураг 5. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гэм буруугийн хэлбэр /2015-2020 он/



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 3 гэмт хэрэг тутмын нэг нь согтуугаар, 4 хэрэг тутмын нэгийг нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүн үйлдсэн. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг сүүлийн 3 жилд 11.4-24.4 хувиар тус тус өсчээ.

Улсын хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 2019 онд 32.9 хувь, 2020 онд 11.1 хувиар тус тус өссөн бөгөөд архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед гэмт хэрэг үйлдэгдсээр байгаа тул нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас архи согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ явуулж байгаа цэгийн тоог багасгах, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр хийх ажлыг сайжруулах шаардлагатай байна. Энэ үүднээс худалдаа үйлчилгээ явуулж байгаа цэгийн тоон мэдээллийг сүүлийн 3 жилийн байдлаар хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 1. Улсын хэмжээнд архи согтууруулах ундааны зүйлээр худалдаа, үйлчилгээ явуулж буй цэгийн мэдээлэл

№	сар, улирал, жил	Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр										Хяналт шалгалтын чиглэлээр зохиосон арга хэмжээ	
		Зөвшөөрөлтэй цэгийн тоо /цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн мэдээлэл/								Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар хүргүүлсэн санал		Ерөнхий	Тусгай
		Үйлдвэр	Худалддаг цэгийн тоо			Үйлчилдэг цэгийн тоо							
			Бөөний төв	Дэлгүүр		Ресторан, зоогийн газар	Баар		Кафе	Хүргүүлсэн саналын тоо /аж ахуйн нэгж бүрээр/	Шийдвэрлүүлсэн тоо /аж ахуйн нэгж бүрээр/		
Орон сууцны хороолол дахь	Гэр хороолол дахь	Диско	Караоке										
1	5	6	7	8	9	10	11	12	13	14	15		
1.	2018 он	59	283	2781	5170	1144	425	877	732	104	40	228	523
2.	2019 он	35	243	2691	4432	1116	329	815	649	257	160	350	743
3.	2020 он	87	275	2890	5100	1290	357	942	638	86	55	149	650
	Нийт	181	801	8362	14702	3550	1111	2634	2019	447	255	727	1916

Сүүлийн 3 жилд архи согтууруулах ундаагаар худалдаа явуулж буй цэгийн тоон дундажыг тооцон харуулбал бөөний төв 260, дэлгүүр 7688, үүнээс гэр хороололд 4900, диско, караоке бар 1250, кафе 673, нийт 10275-11492 цэг ажиллаж¹ байна.

Архи, дарс, шар айраг, спиртийн үйлдвэр болон 10000 хүн ам тутамд ногдох согтууруулах ундаа зарж, борлуулах зөвшөөрөлтэй цэгийн тоо, мөн нэг хүнд ногдох архи, согтууруулах ундааны

¹ НХЖХОНАБХ албаны тоон мэдээлэл.

хэмжээ зэргийг хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын сөрөг үзүүлэлтүүдэд хамруулдаг бөгөөд өмнөх жилээс 20-оос дээш хувийн бууралттай бол аюулгүй байдал хангагдсан гэж үздэг² ажээ.

Монгол Улсын хүн амын ихэнх нь Улаанбаатар хотод амьдарч, худалдаа үйлчилгээ төвлөрсөнтэй уялдуулан согтууруулах ундаа борлуулах, үйлчлэх цэгийн тоог авч үзэхэд 2008-2017 онд тасралтгүй өсөж, 2017 онд 4779 болсон нь 2008 оноос 1.4 дахин нэмэгдсэн³ бол 2018-2020 онд 10275-11492 цэг ажиллаж байгаа бүртгэл судалгаа байна.

Зураг 6. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг зүйл ангиар нь задлан харуулбал /2015-2020 он/



Үүнээс үзвэл энэ төрлийн гэмт хэргийн 85.3 хувь нь Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйл Хүний эрүүл мэндэд хөнгөн гэмт хэрэг санаатай учруулах гэмт хэрэг, 8 хувь нь хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Зураг 7. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн газар



2020 онд бүртгэгдсэн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 44.1 хувь нь гэр орон сууцанд, 27.5 хувь нь гудамж талбайд, 11.4 хувь нь олон нийтийн газар, 0.1 хувь нь нийтийн тээвэрт, 0.1 хувь нь авто замд, 12.4 хувь нь бусад газарт үйлдэгдсэн.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг сүүлийн 6 жилийн үзүүлэлттэй харьцуулахад гэр орон сууц, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг ижил түвшинд, олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг 55.8 хувь, авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 53.3 хувь, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 14.8 хувиар тус тус буурсан байна.

Зураг 8. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн “Гудамж талбай”-д үйлдэгдсэн байдал



Зураг 9. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн “Олон нийтийн газар”-т үйлдэгдсэн байдал


² Эрүүл мэнд, эдийн засагт учруулах архины дарамтыг судлах судалгааны ажлын тайлан.

³ 1212.мн Согтууруулах ундааны хэрэглээ, үйлдвэрлэлийн өнөөгийн байдал



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг гудамж талбайн 1335 буюу 65.6 хувь нь орон сууцны хороолол, гэр хорооллын гудамжинд, олон нийтийн газрын 447 буюу 53.1 хувь нь баар, ресторан, зочид буудалд үйлдэгдсэн байна.


Зураг 10. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг /2015-2020 он/



Хүснэгт 2. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг үйлдэгдсэн сараар нь харьцуулан харуулбал /2015-2020 он/

	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
2015 он	942	667	785	721	604	669	746	646	544	727	714	703
2016 он	877	598	747	828	659	816	758	743	646	625	755	639
2017 он	897	549	619	562	575	639	698	916	772	863	897	825
2018 он	963	767	900	782	798	728	829	767	718	674	552	656
2019 он	882	769	701	727	654	625	597	629	713	745	635	588
2020 он	820	641	482	570	556	602	597	693	723	650	695	376
Нийт	5361	3961	4193	4143	3988	4037	4220	4404	4106	4288	4213	3745

Зураг 11. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо, криминологи зураглал /2011-2020 он/



Зураг 11-д: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо сүүлийн 10 жилийн дундажыг гаргавал 163 гэмт хэрэг буюу 1.6 хувиар өссөн байна. Динамик үзүүлэлтээр Монгол улсын хэмжээнд уг гэмт хэргийн тоо сүүлийн 2 жилд 9.5-10.4 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч 10 жилийн дунджаар тооцож үзэхэд 2021 онд 7568 болж 2020 оноос 2.2 хувиар өсөх төлөвтэй байна.

Хоёр. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 2015-2020 онд нийт 51555 хүн хохирсноос 19599 эмэгтэй, 2506 хүүхэд байна.

Хүснэгт 3. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчдын хүйсийн харьцаа 2015-2020 он

Он	Хохирогчийн тоо	Үүнээс:	
		Эмэгтэй	Хүүхэд
2015 он	8423	3379	373
2016 он	8664	3350	323
2017 он	8980	3430	430
2018 он	9148	3363	445
2019 он	8542	3154	505
2020 он	7798	2923	430
Нийт	51555	19599	2506


Энэ төрлийн гэмт хэргийн улмаас 2015-2020 онд нийт 70 хүн нас барж, 46213 хүн гэмтсэн бөгөөд үүнээс 2020 онд 19 хүн нас барж, 7202 хүн гэмтсэн байна.

Хүснэгт 4. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчийн тоо, гэмт хэргийн зүйлчлэл /2015-2020 он/

Зүйл, анги	2015	2016	2017	2018	2019	2020	нийт
11.1	429	421	396	294	247	308	2095
11.3	24	37	57	26	35	39	218
11.4	608	682	652	410	333	555	3240
11.6	7270	7452	7854	8216	7717	6784	45293
11.7	92	72	21	202	210	112	709
Нийт	8423	8664	8980	9148	8542	7798	51555


2020 онд энэ төрлийн гэмт хэрэгт нийт 7798 иргэн хохирсон нь өмнөх оноос 744 буюу 8.7 хувиар өссөн, 6784 буюу 86.9 хувь нь Эрүүгийн хуулийн Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах 11.6 зүйлд заасан гэмт хэргийн улмаас хохирсон байна. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 31.3 хувь нь 18-29 насны, 34.1 хувь нь 30-39 насны, 17.2 хувь нь 40-49 насны, 9.1 хувь нь 50-59 насны, 2.7 хувь нь 60-аас дээш насныхан байна.

Зураг 12. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчийн боловсролын байдал



Гэмт хэрэгт хохирогчдийн 5 хувь нь дээд, 8 хувь нь тусгай дунд, 44.5 хувь нь бүрэн дунд, 11.5 хувь нь бүрэн бус дунд, 7 хувь нь бага боловсролтой, 4 хувь нь боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг 13. Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын мөнгөн дүн /2020 он/




Гурав. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн холбогдогч

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 2015-2020 онд нийт 44652 хүн холбогдсон бөгөөд 5617 буюу 12.6 хувь нь эмэгтэй, 37680 буюу 84.4 хувь нь эрэгтэй, 1355 буюу 3.0 хувь нь хүүхэд байна.

Харин 2020 онд энэ төрлийн гэмт хэрэгт 6806 хүн холбогдсоны 830 буюу 12.2 хувь нь эмэгтэй, 254 буюу 3.7 хувь нь хүүхэд байна. Гэмт хэрэгт холбогдогчдыг өмнөх онтой харьцуулахад 134 буюу 2 хувиар өсчээ.

Зураг 14. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдогчид, /2015-2020 он/




Зураг 15. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдогчийн хүйс /2015-2020 он/




Насны бүлгээр авч үзвэл 2381 буюу 35 хувь нь 18-29 насны, 2298 буюу 33.8 хувь нь 30-39 насны, 1254 буюу 18.4 хувь нь 40-49 насны, 520 буюу 7.6 хувь нь 50-59 насны, 99 буюу 1.5 хувь нь 60-аас дээш насны, 254 буюу 3.7 хувь нь насанд хүрээгүй хүн энэ төрлийн гэмт хэргийг үйлдсэн байна.


Зураг 16. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн сэжигтний тоо, насны бүлгээр нь /2015-2020 он/



Зураг 17. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн сэжигтний тоо, гэмт хэргийн зүйлчлэлээр /2015-2020 он/



Зураг 18. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн холбогдогчдыг нийгмийн байдлаар нь /2015-2020 он/




Дөрөв. Шүүх эмнэлгийн шинжилгээний талаар

Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн 2015-2020 онд нийт 363954 шинжилгээ хийснээс 257212 буюу 70.6 хувь нь хүний биед гэмтлийн зэрэг тогтоосон байна. Шинжилгээ хийлгэсэн хүмүүсийн 7796 хүнд гэмтэл, 14012 хүндэвтэр гэмтэл, 85600 хөнгөн гэмтэл авсан болох нь тогтоогдож, 28495 шинжилгээ гэмтлийн зэрэг тогтоогдоогүй байна.


Зураг 19. Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнд хийсэн шинжилгээ, харьцуулсан байдлаар



Зураг 20. Гэмтлийн зэрэг тогтоогдоогүй шинжилгээ




Хүнд гэмтэл




■ 2015 он ■ 2016 он ■ 2017 он
■ 2018 он ■ 2019 он ■ 2020 он

Хүндэвтэр гэмтэл



■ 2015 он ■ 2016 он ■ 2017 он
■ 2018 он ■ 2019 он ■ 2020 он

Хөнгөн гэмтэл




■ 2015 он ■ 2016 он ■ 2017 он
■ 2018 он ■ 2019 он ■ 2020 он

Тав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ял эдлэж буй ялтны мэдээлэл

Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн 11.1-11.7 зүйл ангиар 2015-2020 онд шүүхээр ял шийтгэгдсэн 2555 ялтан байна. Нийт ял эдэлж байгаа ялтны 66.6 хувь нь бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулсан байна.

Зураг 21. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэн ял шийтгэгдсэн ялтаны тоо



Хүснэгт 5. Ялтны ял шийтгэгдсэн зүйл ангиар нь харуулбал


	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
11.1 зүйл	284	268	265	263	266	357
11.2 зүйл	118	133	69	16	45	20
11.3 зүйл	64	2	4	3	2	1
11.4 зүйл	78	12	6	8	12	23
11.6 зүйл	5	14	4	30	43	32
11.7 зүйл	6	4	2	27	34	35

Зургаа. Гадаадын зарим оронд хүний эрүүл мэндийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр архи хэтрүүлэн хэрэглэсний улмаас дэлхийд 1 жилд 3 сая, өөрөөр хэлбэл, 1 минутад 6 хүн нас барж байна. Эдгээр хүний 4 хүн тутмын 3 нь эрэгтэй байна. Мөн 2016 оны байдлаар дэлхийн 15, түүнээс дээш насны 1 хүн жилд 6.4 литр “спирт” хэрэглэж байгаа тооцоо гарчээ.

Оросын холбооны улсад үйлдэгдсэн хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн талаарх мэдээллийг 2013-2017 оны байдлаар хүргүүлж байна. ОХУ-д 2017 онд энэ гэмт хэрэг 295212 бүртгэгдсэний 9738 хүний амь нас хохироосон гэмт хэрэг, 24552 бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг үйлдэгдсэн байх бөгөөд нийт гэмт хэргийн 14.3 хувийг эзэлж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд жилд дундажаар 6-10.5 хувиар энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурчээ.

Зураг 22. Хүний эрүүл мэндийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг /2013–2017 он/



Тус улсад энэ төрлийн гэмт хэргийг бууруулахад мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологийг нэвтрүүлэх, интернет орчны хэрэглээг нэмэгдүүлэх, гудамж талбай, олон нийтийн газар байршуулсан хяналтын камерын нэгдсэн систем нь үр дүнгээ үзүүлсэн байна. Мөн Засгийн газраас олон улсад хэрэгжүүлдэг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний цэгүүдэд тавих хяналтыг нэвтрүүлж, идэвхтэй шинэчлэл хийж ажилласнаар гэмт хэргийн гаралт буурчээ. Албан ёсны статистик мэдээнээс харахад ОХУ-д 2016 онд нийт 2 сая гэмт хэрэг бүртгэгдсэнээс 400.000 буюу нийт гэмт хэргийн 20 орчим хувийг согтуугаар үйлдсэн гэмт хэрэг⁴ эзэлсэн. Архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, борлуулах цагийн хязгаарлалтад өөрчлөлт оруулснаар согтууруулах ундааны хэрэглээ, түүний сөрөг үр дагавруудыг бодитойгоор бууруулдаг бөгөөд гэмт хэргийн түвшинд шууд хамаарсан байна.⁵

Засгийн газраас орон нутгийн удирдлагуудад согтууруулах ундаагаар үйлчлэх, борлуулах цагийн хуваарийг тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар үүрэг, чиглэл өгснөөр улсын хэмжээнд согтууруулах ундааг 23:00–08:00 цагт кафе, бааранд худалдаалахыг хориглож, үйлчилгээний газрууд ажлын өдрүүдэд 10:00-20:00 цагт үйлчлэх болсноор гэмт хэргийн гаралт бодитой буурсныг Засгийн газраас явуулж байгаа бодлоготой шууд хамааралтай гэж судлаачид үзжээ.⁶

Бүгд Найрамдах Хятад Ард Улс: Эрүүгийн хуулийн 4 дүгээр бүлэг “Хүний эрх, иргэдийн ардчилсан эрхийг зөрчих гэмт хэрэг”-ийн 234 дүгээр зүйл “Бусдад санаатай гэмтэл учруулсан бол 3 хүртэл жилээр хорих, эсхүл баривчлах, хянах ялаар шийтгэнэ. Дээрх гэмт хэргийг үйлдэж бусдад хүнд гэмт учруулсан бол 3-10 жилийн хорих ялаар шийтгэдэг байна. Хэрэв уг гэмт хэргийн улмаас бусдыг үхэлд хүргэсэн, эсхүл онц харгис хэрцгий аргаар хүнд хэлбэрийн гэмтэл хүргэсэн бол 10 хүртэл жилээр хорих, бүх насаар нь хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэдэг байна.”⁷ 2021 оны 04 дүгээр сарын байдлаар энэ төрлийн 42 эрүүгийн гэмт хэрэгт цаазаар авах ялыг оногдуулжээ.

Санаатайгаар хүн гэмтээх нь зарим тохиолдолд үхэлд хүргэж, бусдын амьд явах эрхийг ноцтой зөрчиж эд эрхтнийг тухайлбал хуруу, чихийг тайрч, эрхтний хэвийн үйл ажиллагааг

⁴ https://xn--b1aew.xn--p1ai/upload/site1/document_news/009/338/947/sb_1612.pdf

⁵ (Babor et al, 2010). Carpenter, Dobkin, 2010; Popova et al, 2009; Wilkinson et al., 2016). Babor T, Caetano R, Casswell S, Edwards G, Giesbrecht N., Graham K., Rossow I. (2010)

⁶ (Carpenter, Dobkin, 2010; Popova et al., 2009; Wilkinson et al., 2016)


⁷ <https://slidesplayer.com/slide/11714157/> "第四章 侵犯公民人身权利、民主权利罪 第一节 侵犯公民人身权利、民主权利罪概述 一概念和特征"

алдагдуулсан, үе мөчний саажилт, мэдрэлийн эмгэг, сонсгол муудах, хараагүй болгодог байна. Гэмтэл нь ихэвчлэн хүчирхийллийн хэлбэрээр явагддаг, тухайлбал хутга, буу, саваа, чулуу, цохилт, өшиглөлтийг шууд хэрэглэх, насанд хүрээгүй хүмүүс, сэтгэцийн өвчтнүүд, гэм буруугүй хүмүүс, амьтад зэргийг шууд бусаар хорлох зорилгоор ашиглах, хор болон химийн бодис, цацраг туяа, лазер гэх мэт хэрэгслүүд бусдад хор хөнөөл учруулдаг.

Энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн 16-аас дээш насны, эрүүгийн хариуцлага хүлээх чадвартай хүнд оногдуулдаг. Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт зааснаар 14 нас хүрсэн боловч 16 нас хүрээгүй хүнийг санаатайгаар гэмтээж, хүнд гэмтэл, үхэлд хүргэсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна. Энэ гэмт хэрэг нь шууд буюу шууд бус санаатайгаар үйлдэгдэж, гэмтлийн зэрэг тогтоогдсон байх ёстой. Тодорхой тохиолдолд зөрчлийн шалтгаан, шүүгдэгч, хохирогчийн ердийн харилцаа, ашигласан багаж хэрэгсэл, халдлагын байршил, зөрчлийг хэрэгжүүлэх арга зэрэг янз бүрийн хүчин зүйлийг судалж, хүчирхийллийн шинж байдлыг үнэн зөв тодорхойлдог байна.⁸

Англи Уэльс Улс: Сүүлийн хорин жилийн хугацааны гэмт хэргийн судалгаанаас (CSEW) хүч хэрэглэсэн гэмт хэргийн 1981 - 2020 онд бүртгэгдсэн мэдээллийг⁹ хүргүүлж байна. Нийт хүч хэрэглэсний улмаас хүний эрүүл мэнд хохирсон үйлдэл 1995 онд 4.5 сая байсан бол 2020 оны эхний улирлын байдлаар 1.2 сая 73 хувиар буурсан байна. Хүч хэрэглэсэн гэмт хэргийг гэмтэлтэй хүчирхийлэл (шархдах, гэмтэл учруулах), гэмтэлгүй хүчирхийлэл гэж 2 ангилдаг. Хүч хэрэглэсэн гэмт хэрэгт дээрэм, бусдын биед гэмтэл учруулах, бусдын биед хөнгөн хохирол учруулах, гэмтэл учруулахгүйгээр халдах гэмт хэргүүд багтдаг ажээ.

Зураг 23. Англи, Уэльсийн гэмт хэргийн судалгаагаар хүчирхийллийн гэмт хэргийн тооцоог урт хугацаанд бууруулж байгааг харуулсан /1981.12 сараас 2020 оны эхний улирал/



Энэ төрлийн гэмт хэргийн гаралт 1990-ээд оны дунд үеэс хойш хөнгөн гэмтэл учруулсан хүчирхийлэл 84 хувь, гэмтэл тогтоогдоогүй хүчирхийлэл 65 хүртэл хувиар тус тус буурсан байна. Гэмт хэргийн гаралт буурч байгаагийн гол шалтгаан нь гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийн хор холбогдлыг таниулах зорилгоор цагдаагийн веб хуудсыг ажлуулж, түүгээрээ дамжуулан олон нийтэд мөрдөн шалгах, иргэдийг аврах зэрэг үйл ажиллагааг харуулснаар сэрэмжлэх ойлголтыг төрүүлж, гэм бурууг тогтоох чиглэлээр цаг хугацаа, хүн хүч зарцуулахаас илүүтэй иргэдэд өөрсдийн үйлдлийг хянах, ухамсарлуулах сэдлийг бий болгосон нь гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлсөн.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүч хэрэглэсэн гэмт хэргийн хохирогч, сэжигтнүүдийн хоорондын харилцаанд хийсэн дүн шинжилгээнээс үзвэл эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэргийн дийлэнх хувийг ойр дотны харьцаатай, хамтран амьдрагч нараас үйлдсэн бөгөөд 22 хувь нь гэр бүлийн гишүүдээс үйлджээ. 2020 оны эхний улиралд хутга, мäs, галт зэвсэг бусад зүйлс ашиглан үйлдсэн гэмт хэрэг 47388 бүртгэгдсэн нь өмнөх оноос гэмт 6 хувиар өсч, 22012 нь хүнд гэмтэл учруулсан.


Мөн энэ хугацаанд бие махбодийн хүчирхийлэлд 16-74 насны хүмүүс илүү олон өртсөн бөгөөд хүчирхийлэл үйлдэгчдийн 43 хувь нь таньдаг, 41 хувь нь үл таних хүн, үлдсэн 16 хувь нь зүс таних хүн байна. 20-29 насныхан нийт хүн амын 13 орчим хувийг эзэлж байсан бол цагдаагийн

⁸ <https://slidesplayer.com/slide/11714157/> "第四章 侵犯公民人身权利、民主权利罪 第一节 侵犯公民人身权利、民主权利罪概述 一概念和特征"

⁹ Хүний эрүүл мэндийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийг хүчирхийллийн гэмт хэрэг гэж үздэг байна.

байгууллагад бүртгэгдсэн хүчирхийллийн гэмт хэргийн 25 хувь нь энэ насныхан хохирогч болжээ. Хөгшин болон бага насныхан хохирогч болох магадлал бага гэсэн судалгаа гарсан. Тухайлбал, 80 ба түүнээс дээш настай хүмүүс хүчирхийллийн гэмт хэргийн 1 хувьд хохирсон бол нийт хүн амын 5 орчим хувийг эзлэх, харин 10-аас доош насны хүүхэд нийт хүн амын 12 хувийг эзэлж байгаа боловч хохирогчдын 3 хувийг эзэлж байна.

Зураг 24. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүчирхийллийн гэмт хэрэгт өртсөн хохирогчийн нас, Англи улс 2020 оны 3 сар



CSEW-ийн 2017 оны 3-р сараас 2019 оны 3-р сарыг дуустал нэгтгэсэн мэдээллээс харахад 10-15 насны хүүхдүүдийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэгт хөвгүүдэд илүү өртсөн бөгөөд 15 орчим хувь нь цагдаагийн байгууллагын анхааралд өртжээ.

ДҮГНЭЛТ

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2015-2020 онд 50775 бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 31 хувийг эзэлж байна. Энэ төрлийн гэмт хэргийн 61.6 хувь нь нийслэлд, 38.4 хувь нь орон нутагт бүртгэгджээ. Энэ хугацааны гэмт хэргийн гаралтыг тооцон үзвэл 2015-2017 онд 1.3-3.5 хувийн өсөлттэй, 2018-2020 онд 9.5-10.4 хүртэл хувиар буурсан байна.

Сүүлийн жилд энэ төрлийн гэмт хэрэг буурч байгаа нь дэлхий нийтэд тархсан коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлсэн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн шийдвэр, хорио цээрийн дэглэм, хязгаарлалтын үед иргэдийн архи, согтууруулах ундааны хэрэглээ буурсантай шууд холбоотой байна.

Нийслэл хот болон хүн ам ихээр төвлөрсөн суурин газруудад 2020 онд энэ төрлийн гэмт хэрэг илүү олон бүртгэгдсэн байх бөгөөд орон нутагт үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн дундаж 135, дунджаас дээгүүр үзүүлэлттэй 10 аймаг, дунджаас доогуур үзүүлэлттэй 11 аймаг байгаагаас Төв аймагт 273, Орхон аймагт 214 буюу хамгийн их, Говь-Алтай аймагт 44, Говьсүмбэр аймагт 64 буюу хамгийн бага гэмт хэрэг бүртгэгдсэн.

Харин нийслэлд гэмт хэргийн дундаж үзүүлэлт 253, Баянзүрх дүүргийн цагдаагийн газар хамгийн олон гэмт хэрэг, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Багануур, Багахангай дүүргүүдийн цагдаагийн хэлтэст хамгийн цөөн гэмт хэрэг бүртгэгджээ. Дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдэд бүртгэгдсэн гэмт хэргийг өмнөх онтой харьцуулахад Чингэлтэй дүүрэгт 4.2 хувь, Налайх дүүрэгт 27.8 хувиар өсч, бусад дүүргүүдэд буурсан байна.

Энэ төрлийн гэмт хэрэг жилийн 1, 3, 4, 6-11 саруудад хамгийн их давтамжтай бүртгэгдсэн. Гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл 44.1 хувь нь гэр орон сууцанд, үүний 45.3 хувь гэр хороололд үйлдэгдсэн байх ба 2 хэрэг тутмын нэгийг согтуугаар, 3 хэрэг тутмын нэг нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүн үйлджээ. Энэ төрлийн гэмт хэргийн 60 хувь нь 19-06 цагт, 39.6 хувь нь

архидан согтуурсан үедээ үйлдэгдсэн бол сүүлийн 3 жилд согтуугаар үйлдэгдэх нь 11.4-24.4 хувиар өссөн. Энэ нь архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулж байгаа цэгийн тоо нэмэгдсэн, Нийслэлийн Засаг даргын захирамжаар согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаар цаг үеийн онцлог байдлаас шалтгаалан 22:00-04:00 цаг хүртэл ажиллуулж байгаатай холбоотой гэж үзэж байна.

Энэ гэмт хэрэгт холбогдогчийн 65.4 хувь нь 18-39 буюу сурч, хөдөлмөрлөх насны залуус байх бөгөөд гэр бүлийн таарамжгүй харилцаа, архи согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн, хууль эрх зүйн мэдлэггүй, бусадтай харилцах харилцаа, хандлага муутай байдал нь гэмт хэрэгт холбогдон, бусдыг хохироож, улмаар шүүхээр ял шийтгэгдэж байна.

Систем динамикийн загварчлалаар согтууруулах ундаа худалдах цагийн хязгаарлалтыг нэмэгдүүлэх, цагдаагийн хүн хүчийг нэмэх, шилжин суурьшилтыг хязгаарлах зэрэг зарим төрлийн арга хэмжээ авснаар гэмт хэргийн гаралт богино хугацаандаа буурах боловч урт хугацаандаа боловсролын байгууллагын төсвийн хувь хэмжээг нэмэгдүүлж бүх шатны боловсролын хөтөлбөрийг шинэчлэх, ажлын байрыг нэмэгдүүлж, хот төлөвлөлт, шилжилт хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулах эсэхээс хамаарч энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг цаашид 20 хүртэл хувиар бууруулах боломжтой тооцоо судалгаа гарсан.

Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 2019 онд зохион явуулсан “Нэг хором” аян үр дүнтэй ажил, арга хэмжээ болсон бөгөөд тухайн гэмт хэргийн хор холбогдол, харилцаа хандлагаас үүдэлтэй учирч буй хохирлыг харуулсан богино хэмжээний шторк, нэвтрүүлэг, сургалт сурталчилгаа, уриалга зэргийг оновчтой байдлаар хүргэсэн нь олон нийтэд хүрч, энэ төрлийн гэмт хэргийн гаралтад нөлөөлөн 2018-2020 онд 9.5-10.4 хүртэл хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан.

Архи, согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулж буй газруудад тавих хяналтыг сайжруулж, гаргасан зөрчилд оногдуулах хариуцлагыг чангатгах, архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг, үйлчилгээ үзүүлдэг цэгийн тоо болон цагийн хуваарийг багасгах талаар нутаг дэвсгэрийн хэмжээнд гаргасан тооцоо судалгаа бүхий саналыг холбогдох төрийн захиргааны байгууллагуудад хүргүүлж, шийдвэрлүүлэх ажлыг идэвхжүүлэх шаардлагатай байна.

Хувь хүний халдашгүй эрхийг хуулиар хэрхэн хамгаалсан, гэмт хэргийн улмаас өөрт болон өрөөл бусдад учирч буй хор холбогдол, эрсдэлүүдийн талаар мэдээ, мэдээлэл, контент, подкастуудыг бэлтгэн хүргэж, хүүхэд, залууст эрх зүйн боловсрол, төлөвшил олгох чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарсан ажил, арга хэмжээг зохион байгуулах нь үр дүнтэй ажил болно гэж дүгнэж байна.

ДҮН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС